

түүнийг "Үнэнч шударга хатан"-аар өргөмжилсөн байдаг.

Тэрээр 1612 онд жаран гурван насан дээрээ нас баржээ. Монголд ч мөн Хятад оронд ч түүнийг дурсан мөрөөдөж маш олон бичгийн мэргэд түүнийг шүлэглэн магтаад, уран зураачид түүний хөрөг зургийг зурж бүтээсэн байдаг. Түүний алдар гавьяаг дурсахын төлөө түүхэнд түүний амьдарч байсан Хөх хотыг нэгэн үе "Юнгэн хатан хот" гэж дуудаж байжээ.

Юнгэн хатан Монгол оронд шарын шашин дэлгэрүүлэхэд хүч гарган зүтгэсэн байна. Алтан хан шарын шашныг Түвдээс оруулан авчрахад Юнгэн хатан их үйлдэл үзүүлсэн тухай сурвалж бичигт тэмдэглэгдсэн байдаг. Шарын шашин Монгол оронд дэлгэрсний дараа тэр бас олон чухал ажил хийжээ. Тухайлбал 1586 онд Далай лам Юнгэн хатанд зарлиг буулгаж "Балбын орон /одоогийн Непал/-аар алтан титэм хийлгэж, дээд зуу Шигэмүни /Шажамүни/ бурханд өмсгөөд ... хутаг оршуулсан" гэсэн тэмдэглэл Монголын судар бичгүүдэд байдаг.

Юнгэн хатан Амудай Сэцэн хан, Бодашир хунтайж нартай хамтран, ширээт гүүш цорж Аюуш, Ананда Манчир болон баруун гурван түмний хэлмэрч мэргэдийг зохион байгуулж, 1602-1607 он хүртэл зургаан жилийн хугацаанд "Ганжуур"-ыг монгол хэлнээ орчуулсан ажээ. Үүнээс үзэхэд Юнгэн хатан бол Монголын соёлын хөгжилтөнд гавьяа зүтгэл гаргасан хүн юм.

Олон Улсын Харилцааны Дээд Сургууль  
АЛТАН АРГАМЖ

VOL.3

1/2000

МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН АЮУЛГҮЙ

БАЙДАЛ,

ЦӨМИЙН ЗЭВСЭГТҮЙ СТАТУС

Т.Арунсанаа

ОУХС-ийн магистрант

Өнгөрсөн найман жилийн гол үйл явдлууд, ололтуудыг жагсаан үзвээс хэдэн гол үр дүнд хүрсэн нь, мөн хэдэн зөрчилтэй асуудал оршин буй нь илэрч байна. Гол ололтууд гэвэл: цөмийн зэвсэгтэй улсууд Монголыг холбогдуулан мэдэгдэл гаргасан; НҮБ-ын ЕА-аас 53/77D тогтоол батлуулсан; Цөмийн зэвсгээс ангид байх тухай Монгол улсын хууль баталсан явдал байна. Зөрчилтэй асуудлууд нэлээн хэд байгаагаас хамгийн гол нь үндэсний аюулгүй байдал хангагдаж буй эсэх тухай асуудал байна.

Цөмийн зэвсэгтэй улсууд аюулгүйн  
баталгаа гаргасан байдал

Монгол улс өөрийн газар нутгаа цөмийн зэвсэгтүй бүс болгох тухай бодлогоо тунхагласны дараа цөмийн зэвсэгтэй гүрнүүд Монгол улстай холбогдуулан тус бүртээ мэдэгдэл хийсэн юм. Энэ талаар зарим сонин хэвлэлд Монгол улсын аюулгүй байдал хангагдаж буй мэтээр дурдсан байдаг. Тэгвэл бодит байдал дээр эдгээр баталгаа нь Монгол улсын Үндэсний Аюулгүй Байдлын Үзэл Баримтлалд дурдсан "Монгол улсын үндэсний ялгуур ашиг сонирхлыг хангах гадаад дотоод таатай нөхцөл баталгаатай хангагдсан" тухай шалгуурт нийцэж байгаа эсэх нь эргэлзээтэй

юм. Тиймээс Монгол улсын бодлогын үр дүнгийн тухай, Монгол улсын үндэсний аюулгүй байдал хангагдаж буй тухай ярих үед аюулгүйн баталгааны тухай асуудлыг нарийвчлан үзэх хэрэгтэй юм. Өгсөн баталгаануудыг нь тус тусад нь авч үзье. Нарийвчлан үзэхээсээ өмнө хэдүй дутагдалтай, манай улсын аюулгүй байдлын ашиг сонирхлыг бүрэн дүүрэн хангаагүй байж болох боловч энэ талаар гаргасан мэдэгдэл, нааштай байр суурийг нь зохих ёсоор үнэлэх хэрэгтэй юм.

### Оросын Холбооны Улс

Баримт-1: 1993 оны 1-р сарын 20-нд байгуулсан Монгол улс Оросын Холбооны Улсын найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээний 4-р зүйл.

Баримт-2: 1994 оны 3-р сарын 1-нд ОХУ-ын Гадаад Хэргийн Яамны төлөөлөгчийн хийсэн мэдэгдэл. Үүнийг ерөнхийд нь харахад Монгол улс ОХУ-ын хооронд байгуулсан гэрээнд эхлээд энэ тухай асуудлыг хөндөж, харин дараа нь бусад улсын алхмыг харгалзан, ийм гэрээ байгуулсан гэдгээ ОХУ- бусад улсуудад мэдэгдсэн шинжтэй байна. Нэгдүгээр баримтыг нарийвчлан үзвэл ОХУ Монголын бодлогыг "will respect" буюу хүндэтгэн үзэх тухай л өгүүлсэн байна. Түүнээс Монгол улсад аюулгүйн негатив, позитив баталгаа гаргах талаар шууд өгүүлсэнгүй. Энд гарсан "will respect" гэсэн үг нь энэхүү негатив, позитив баталгаа гаргасантай адил жин нөлөөтэй эсэх нь эргэлзээтэй юм. Хоёрдугаар баримтыг авч үзвэл энэ нь а. Монгол улс 1992 онд цөмийн зэвсэггүй бүсийн тухай бодлогоо тунхагласны хариуд бусад улсууд Монголын статусыг хүндэтгэхээр амлах болсыг дурьдаад, б. ОХУ-ын өөрийнх нь байр суурь ямар байна вэ гэдгийг 1993 оны 1 сарын 20-нд байгуулсан гэрээтэй холбон тайлбарлан, үг гэрээний 4-р зүйлийг ишлэл болгон авчээ. Энд мөн аюулгүйн баталгааны тухай өгүүлээгүй байна. Харин –гадаадын цэрэг, -цөмийн зэвсэг, -үй олноор хөнөөх зэвсгийг нутаг дэвсгэртээ байрлуулахгүй, дамжин өнгөрүүлэхгүй гэсэн Монгол улсын байр суурийг хүндэтгэн үзнэ гэдгээ л өгүүлжээ. Үл дэлгэрүүлэх гэрээний оролцогч талуудад цөмийн зэвсэгтэй улсууд аюулгүйн баталгаа гаргаж байсан. Тэгвэл ОХУ (ЗХУ) цөмийн зэвсэгтэй улсуудад 1978 оны 5 сард, 1982 оны

6 сард аюулгүйн баталгаа гаргаж байсан. Цөмийн зэвсэгтэй улсуудын аюулгүй байдлыг хангах талаар олон янзын арга хэмжээ авч болох талаар ч санал болгож байсан. Цөмийн зэвсгийн талаархи суулийн үеийн байр суурийг нь 2000 онд батлагдсан Үндэсний Аюулгүй Байдлын Үзэл Баримтлагаас нь бүр тодорхой мэдэж болно. Тэгвэл тэрхүү баримт бичигт – цөмийн зэвсэг нь ОХУ-ын үндэсний аюулгүй байдлаа хангах чухал хүчин зүйл болох бөгөөд үндэсний аюулгүй байдал шаардсан үед цөмийн зэвсэгтэй улсын эсрэг хүртэл цөмийн зэвсэг хэрэглэж болох тухай өгүүлсэн байдаг.

### БНХАУ

Баримт –1: 1993 оны 10 дугаар сарын 22-нд БНХАУ-ын ГЯД-ны төлөөлөгчийн хийсэн мэдэгдэл. Баримт –2: 1994 оны 4 дүгээр сарын 29-нд Монгол Хятадын хэвлэлийн хамтарсан мэдэгдэл. Нэгдүгээр мэдэгдэлд БНХАУ-а. Монгол улсын цөмийн зэвсэгтэй бүсийн тухай байр суурийг дэмждэгээ, цөмийн зэвсэгтэй бүсийн тухай бодлогыг хүндэлж үзэх тухайгаа өгүүлжээ. БНХАУ "цөмийн зэвсэгтэй бүс, улсуудад" аюулгүйн баталгаа гаргасан тухайгаа дурдаад энэхүү баталгаа нь Монголд ч гэсэн нэгэн адил хамаарна гэж тайлбарласан. Дашрамд дурдахад БНХАУ-ын аюулгүйн баталгаанд дурдагддаг "цөмийн зэвсэгтэй бүс, улсууд" гэсэн нэр томъёог нь "тодорхой бүс байна" гэж олон улсууд үздэг. Удаахи мэдэгдэл нь өмнөхөө давтсан шинжтэй бөгөөд өмнөх мэдэгдэлд дурдсан "to respect" хэмээх үгийн агуулгыг тодруулан "цөмийн болон үй олноор хөнөөх зэвсэг, гадаадын цэргийг газар нутагтаа байрлуулах, дамжин өнгөрүүлэхгүй тухай Монголын бодлогыг" хэмээн өгүүлжээ. Эхний мэдэгдэл дэхь аюулгүйн баталгаа нь "Цөмийн зэвсэгтэй бүс, улсуудын эсрэг цөмийн зэвсэг хэрэглэх буюу хэрэглэхээр заналхийлэхгүй" тухай юм. Өөрөөр хэлбэл БНХАУ Монгол улсад негатив аюулгүйн баталгаа өгсөн. Харин позитив аюулгүйн баталгаа буюу Монгол улс цөмийн зэвсэг хэрэглэсэн түрэмгийлэлийн хохирогч, заналхийлэлийн объект болсон тохиолдолд тусламж үзүүлэх тухай өгүүлээгүй байна. Хятад улс урьд нь 1964, 1978, 1983 онд аюулгүйн баталгааны талаар мэдэгдэл хийж байсан. Эдгээр мэдэгдлүүдийг нь үзвэл бүгд негатив аюулгүйн баталгааны тухай өгүүлсэн байдаг ба харин 1982

оны мэдэгдэлдээ "нөхцөл тавихгүй" гэж оруулсан нь шинэлэг зүйл болсон бөгөөд анхаарал татахуйц юм. Харин Монгол улстай холбогдуулан мэдэгдэл гаргаснаасаа хойш 1995 оны 4 дүгээр сарын 5-нд гаргасан мэдэгдэлээрээ цөмийн зэвсэггүй бүсүүд, улсуудад негатив, позитив аюулгүйн баталгаа гаргасан.

## АНУ

1993 оны 10, 12 дугаар саруудад АНУ-ын Монгол дахь ЭСД, Төрийн Департаментгаас гаргасан мэдэгдэл. Энэхүү мэдэгдлийг гурван хэсэг болгон үзвэ. Эхний хэсэгт АНУ 1968 оны гэрээний тухай дурьдан, Монголын шийдвэрийг дэмжин талархаж буйгаа, удаахи хэсэгт хоёр янзын баталгааны тухайд:

- а. НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн тусламж өгүүлэх тухайд,
- б. Цөмийн зэвсэгтэй улстай холбоотон бус цөмийн зэвсэгтэй улсын эсрэг цөмийн зэвсэг хэрэглэхгүй гэсэн АНУ-ын баталгааг Монгол улс хүртэх тухай өгүүлсэн. Харин сүүлийн хэсэгт нь – Монголд заналхийлэл учирсан тохиолдолд Аюулгүйн зөвлөлийн бусад гишүүдийн хамтаар зохих алхам хийх тухай дурджээ. Үүнийг цааш нь нарийвчлан үзвэл хоёрдугаар хэсэгт АНУ цөмийн дипломатын уламжлалт хэллэг "attack" болон "not allied with" хэмээх үгнүүдээ хэрэглэжээ. Эдгээр үг хэллэгийг хэрхэн ойлгох талаар болон олон улсын хэмжээнд нэг хэв загварт оруулах тухайд ихээхэн асуудал өрнөж байсан юм. Хоёрдугаар мөрөнд өгсөн аюулгүйн баталгаа нь позитив, негатив баталгаа болох бөгөөд "not allied with nuclear weapon State" гэснийг нь үзвэл негатив баталгаа нь нөхцөл тавьсан баталгаа байна. Позитив баталгааны тухай нэгэн зүйл дурдахад – позитив баталгааны үр өгөөжтэй, бодитой байдлын талаар олон улсын яриа хэлцэл өргөн хэмжээнд өрнөж байсан. Учир юун хэмээвээс – хэдийгээр НҮБ-ын АЗ-ийн тусламж өгүүлэх, зохих арга хэмжээ авах тухай, тогтоол батлуулах болно гэх нь сонсоход автай ч хэрэв цөмийн зэвсгээр түрэмгийлсэн, заналхийлсэн улс нь НҮБ-ын АЗ-ийн байнгын гишүүн байгаад АЗ-өөс гаргах тогтоолд хориг тавих эрхээ эдэлсэн тохиолдолд дээрхи алхам нь ямартай ч олон улсын эрх зүйн өнөөгийн нөхцөл байдлын хувьд биелэгдэх боломжгүй болох юм.

## Умард Ирланд, Их Британий Нэгдсэн Вант Улс

1993 оны 11 дүгээр сарын 1-нд Умард Ирланд, Их Британий Нэгдсэн Вант Улсын Засгийн Газраас мэдэгдэл хийв. Уг мэдэгдлийг өмнөхийн нэгэн адилгаар гурван хэсэг болгон үзвэ. Эхний хэсэгт Их Британий Засгийн Газар Монгол улсын Засгийн Газрын бодлого, шийдвэрийг сайшаан хүлээн авч байгаа тухайгаа өгүүлжээ. Энэ хэсэгт мөн Ул дэлгэрүүлэх гэрээний тухайд дахин дурдсан байна. Удаахи хэсэгт нь Ул дэлгэрүүлэх гэрээний оролцогч Монгол улс Их Британий аюулгүйн баталгааг хүртэх тухай өгүүлжээ. Гэхдээ уг баталгаандаа "цөмийн зэвсэг хэрэглэсэн, хэрэглэхээр заналхийлсэн явдлын хохирогч буюу объект болсон тохиолдолд НҮБ-ын АЗ-ийн тусламж олгох" хэмээн дурдсан учир уг баталгаа нь позитив баталгаа болно. Гуравдахь хэсэгт нь Их Британи негатив аюулгүйн баталгаа гаргасан байна. Үүндээ "attack", "in association or alliance with" хэмээн цөмийн дипломатын уламжлалт хэллэгээ ашиглажээ. "except in the case" гэснээс нь үзвэл энэ баталгаа нь нөхцөл тавьсан аюулгүйн баталгаа болох юм. Ийнхүү Их Британи мэдэгдэлдээ позитив аюулгүйн баталгаа, нөхцөл тавьсан негатив баталгаа гаргажээ. Үүнээс өмнө Их Британи 1978 онд мөн аюулгүйн баталгааны тухай мэдэгдэл хийж байсан бол дараа нь 1995 онд дахин мэдэгдэл гаргасан.

## Франц

1994 оны 1-р сард Францын Гадаад Хэргийн Яам мэдэгдэл хийсэн. Уг мэдэгдлийг нь дүгнэж үзвэл а. эхний хэсэгт нь Ул дэлгэрүүлэх гэрээний тухайд өмнөх улсуудын нэгэн адилгаар дурдсан бөгөөд уг хэллэгийн хувьд авч үзвэл нөхцөл тавьсан баталгаа байна. Өмнөх мэдэгдэл хэмээн, шууд бусаар өгүүлжээ. Тэгвэл энэ мэдэгдэлд дурдагдсан өмнөх мэдэгдэл гэж юу вэ гэсэн асуулт гарах нь зүйн хэрэг юм. Франц улс 1982 онд цөмийн зэвсэггүй улсуудад нөхцөл тавьсан аюулгүйн баталгаа өгсөн. Хожим нь 1995 онд негатив, позитив аюулгүйн баталгаа өгсөн.

## Аюулгүйн баталгаануудыг дахин авч үзэхүйд

Монгол улс өөрийн нутаг дэвсгэрээ цөмийн зэвсэггүй бус болгох тухай бодлогоо 1992 онд тунхагласнаас хойш 1993 оны 1 дүгээр сараас 1994 оны 1 дүгээр сар хүртэлх нэг жилийн хугацаанд цөмийн зэвсэгтэй 5 гүрэн Монгол улсын бодлогыг сайшаан хүлээн авсан, дэмжсэн утга агуулга бүхий мэдэгдэл хийж, хоёр талын гэрээнд хүртэл энэ талаар тусган оруулж байсан. Гэхдээ эдгээр улсуудын мэдэгдлүүд нь бүгд адил агуулга ач холбогдолтой байгаагүй. Ийнхүү цөмийн зэвсэгтэй улсуудын хийсэн мэдэгдэл, хүлээсэн үүргүүдийн нь тухай өгүүлээ. Гэсэн ч үүгээр аюулгүйн баталгааны тухай асуудал хязгаарлагдахгүй юм. Аюулгүйн баталгааны мэдэгдлүүдээс гадна чухал ач холбогдол бүхий өөр олон янзын баримт бичгүүд бий.

### Аюулгүйн баталгааны тухай олон улсын үйл ажиллагаа.

Юуны өмнө аюулгүйн баталгааны тухай өгүүлсэн баримт бичгүүдийг төрөл, онцлогоор нь ангилж үзье.

1. Цөмийн зэвсэг Үл дэлгэрүүлэх тухай гэрээ болон бусад гэрээ конвенцууд,

2. Цөмийн зэвсэггүй бүсийн тухай гэрээнүүд

1 Цөмийн зэвсэгтэй улсуудаас хийсэн мэдэгдэл, меморандум  
2 НУБ-ын тогтоол, шийдвэрүүд

3 Ерөнхий Ассамблейд өргөн барьсан төслүүд,

гэсэн баримт бичгүүдэд аюулгүйн баталгааны тухай өгүүлжээ. Эдгээр баримт бичгүүдийг цар хүрээ, ач холбогдлоор нь —бүс нутгийн,

—олон улсын гэсэн хоёр хэсэгт хуваан үзэж болох юм.

Цөмийн зэвсэг, аюулгүйн баталгаа, цөмийн зэвсэггүй бүсийн тухай авч хэлэлцдэг өөр байгууллага, үйл ажиллагаанд Үл дэлгэрүүлэх гэрээний биелэлтийн талаар авч хэлэлцдэг бага хурлууд орно. Үл дэлгэрүүлэх гэрээний бага хурал 2000 онд хуралдахтай холбогдуулан Бэлтэл хорооны даргын 1998 оны 6 дугаар сарын 9-ний төсөлд- Монгол улсын цөмийн зэвсэггүй бүс,

цөмийн зэвсэгтэй улсуудаас цөмийн зэвсэггүй улсуудад гаргасан аюулгүйн баталгааны тухай дурдсан байдаг. Уг баримт бичгийн 154 дүгээр зүйлд Монголын цөмийн зэвсэггүй бүсийн тухай дурдаж, нэг улс цөмийн зэвсэггүй бус байх, тийм статус нь эрх зүйн хувьд бусад бусуудийн нэгэн адил үндэстэй байх талаар өгүүлсэн. Уг баримт бичгийн 170 дугаар зүйлд аюулгүйн баталгааны талаар: "In this context, these States parties consider that the unilateral decisions made by the 4 nuclear-weapon States, and Security Council resolutions 255(1968) of 19 June 1968 and 984 (1995) of 11 April 1995 on security assurances have not fulfilled the requirements of non-proliferation-weapon States." хэмээн улс орнуудын байр суурийг дүгнэн өгүүлжээ.

НУБ-ын ЕА, Зэвсэг хураах бага хурал зэрэг хурал чуулганаар негатив аюулгүйн баталгааны тухай хэлэлцэх үеэр өнөөг хүртэл байгуулагдан бий болсон аюулгүйн баталгааны зарим дутагдлууд илэрсэн юм. Улс орнуудын дурдаж буй гол гол дутагдлуудад:

А. Цөмийн зэвсэгтэй улсууд цөмийн зэвсгийн талаархи өөрсдийн номлолоо өөрийн буюу нэг улсын аюулгүй байдал, ашиг сонирхолд нийцүүлэн боловсруулдаг тул зарим нөхцөл байдалд цөмийн зэвсэггүй улсын эсрэг цөмийн зэвсэг хэрэглэх явдлыг боломжтой болгосон.

Б. Цөмийн зэвсэгтэй таван гүрэн тус бүртээ өөр өөр нөхцөл тавьж, түүнийгээ хангахыг шаардсанаар цөмийн зэвсэггүй улсууд бүх шалгуурыг нь нэгэн зэрэг хангахад хүндрэлтэй байх болно.

В. Олон улсын эрх зүйн дагуу нэг улсын хийсэн мэдэгдэл нь эрх зүйн хувьд хүчинтэй шинж чанартай ч цөмийн зэвсэгтэй улсууд мэдэгдлээрээ хүлээсэн үүрэг хариуцлагаа буцаан хүчингүй болгох буюу өөрчлөх боломж ихтэй.

Г. Хүчинтэй буй тохиролцоонуудад цөмийн зэвсэгтэй улсуудын гарган тавьсан негатив аюулгүйн баталгааны зарим нөхцлүүд нь нарийн тодорхой бус байгаа нь тэдгээр заалтуудыг өөр өөрөөр тайлбарлан ойлгоход хүргэж болгох талтай. Юуны өмнө, нэг талын мэдэгдэл, бүсийн тохиролцоог тайлбарласан мэдэгдэлд хэрэглэсэн гол гол нэр томъёолыг нарийвчлан тайлбарлаагүй байна. Жишээлбэл Хятадын мэдэгдэл дэхь "цөмийн зэвсэггүй улсууд", Францын мэдэгдэл дэхь "түрэмгийлэл"- (aggression), АНУ, Их Британий мэдэгдэл дэхь "Довтолгоон"-

(*attack*), Франц, Их Британи, АНУ-ын мэдэгдэл дэхь "*in alliance with*", "*in association with*" гэсэн томъёоллууд юм. Хятад, Францын хувьд бусад улсуудаас шаардаж буй цөмийн зэвсэггүй статус нь наг талын мэдэгдэл байх буюу олон улсын эрх зүйн дагуу заавал биелүүлэх (гэрээ г.м) хэлбэртэй байх эсэх болон дээр дурдсан цөмийн зэвсэггүй статусыг нь хянаж шалгаж байх ёстой юу гэдэг нь тодорхой бус байна.

### Дүгнэлт

Монгол улс өөрийн газар нутгаа цөмийн зэвсэггүй бүс болгон зарласнаас нэгээс хоёр жилийн дотор цөмийн зэвсэгтэй хэмээн 1967 оны Үл дэлгэрүүлэх гэрээгээр хүлээн зөвшөөрөгдсөн таван бүрэн Монгол улсын бодлогыг хүндэтгэж буй тухайгаа, аюулгүйн баталгаа өгч буй тухайгаа илэрхийлсэн мэдэгдлүүд хийсэн. Өмнө өгүүлж байсанчлан энэ нь нааштай, сайшаагуштай зүйл юм. Гэсэн хэдий ч эдгээр улсуудын мэдэгдлийг нарийвчлан үзэхэд Монгол улсын үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхлыг хангасан байна гэж хэлэхэд учир дутагдалтай байна. Өөрөөр хэлбэл Монгол улсын цөмийн зэвсэггүй бүсийн талаархи бодлоготой холбогдуулан гаргасан эдгээр мэдэгдэл нь – аюулгүйн баталгаа болж чадахгүй, харин түр зуурын шинж чанар бүхий аюулгүйн мэдэгдэл л байна. Тэдгээр улсууд эдгээр мэдэгдлээ хэдийд ч өөрчлөх бололцоотойгоос гадна, тэгсэн тохиолдолд хариуцлага хүлээх механизмгүй юм. Энэ талаар НУБ-ын Ерөнхий Ассамблейгаас 1996 оны 7 дугаар сарын 8-нд Олон Улсын Шүүхэд "Зэвсэгт мөргөлдөөний үед цөмийн зэвсэг хэрэглэх, түүгээр заналхийлэх нь хууль (олон улсын эрх зүй)-д нийцэх эсэх" талаар зөвлөмж хүсэхэд Олон улсын шүүхээс: "...энэ нь байгаль орчинд, олон улсын эрх зүйн ерөнхий хэм хэмжээнд харшлах боловч улс орны аюулгүй байдал, оршин тогтнох асуудал яригдаж буй үед нийцж болох юм..." хэмээн өгүүлсэн зөвлөмжийг батлахад нийт 14 шүүгчийн санал 7:7 харьцаатайгаар хуваагдаж байжээ.

Дээр дурдсан олон улсын гэрээ, тогтоолууд, хурлын баримт бичгүүд, цөмийн зэвсэгтэй таван улсын аюулгүйн баталгааны тухай мэдэгдэл, тэдгээрийн цөмийн дипломат, цөмийн зэвсэггүй бүсүүд, улсуудын шаардлага, өнөөгийн олон улсын улс төрийн

байдал зэргийг дүгнэн үзэхэд:

-тодорхой нөхцөлд Монгол улсын эсрэг цөмийн зэвсэг хэрэглэгдэж болох боломж оршоор байна,

-тэгж хэрэглэсэн тохиолдолд цөмийн зэвсэггүй улсын эсрэг цөмийн зэвсэг хэрэглэсэн улсад хариуцлага хүлээлгэх олон улсын эрх зүйн тогтолцоо үгүй байна гэсэн дүгнэлтэнд хүрч болох байна. Үүнээс үндэслэн Монгол улсын аюулгүй байдлыг хангах нэгэн арга зам болох цөмийн зэвсэггүй статусаа илүү бодитой, үр ашигтай болгох ямар арга зам байж болох вэ гэсэн асуудал гарч ирэх юм. Учир нь манай улсын бодлого зохих үр дүнд хүрсэн ч НУБ-ын тогтоол, амласан, буцаан татан авч болохуйц мэдэгдэл дээр аюулгүй байдлаа даатгаад зүгээр орхиж болохгүй. Харин илүү бодитой, чанд биелэгдэх тохиролцоо, дэглэмийг баримталж байж үндэснийхээ аюулгүй байдлаа хангаж болно. Үүнд цөмийн зэвсэггүй бусад бүсүүдийн аюулгүй байдлаа хангасан туршлагыг харгалзан үзэх нь зүйтэй. Учир нь бид бусад цөмийн зэвсэггүй бүсүүдээс дутахааргүй бодитой, үр дүнтэй статустай болохоор чармайж байгаа.

### Бид юу хийх вэ?

Монгол улс бол цөмийн зэвсэггүй. Тиймээс ч өөрийн газар нутгаа цөмийн зэвсэггүй хэмээн зарлан, цөмийн зэвсэггүй бүс хэмээх статустай болох бодлого хэрэгжүүлэхээр оролдсон ч "нэг улс цөмийн зэвсэггүй бүс" гэсэн үзэл баримтлал нь цөмийн зэвсэгтэй улсуудын зүгээс хангалттай дэмжлэг хүлээгээгүй. Улс төрийн ийм орчинд манай улсын аюулгүй байдлаа хангах зорилтонд хүргэх хэд хэдэн арга зам байж болох юм. Эхнийх нь олон улсын гэрээ конвенц, Цөмийн зэвсэг олж авах, үйлдвэрлэх, байрлуулахыг хориглосон хоёр болон олон талын гэрээ байгуулана. Энэ талаар цөмийн зэвсэг хэрэглэхийг хориглосон буюу цөмийн зэвсэггүй улсын эсрэг цөмийн зэвсэг хэрэглэх, түүгээр заналхийлэхийг хориглосон, аюулгүйн баталгааны тухай олон улсын конвенц байгуулах талаархи олон улсын чармайлт үргэлжилсээр байна. Хэрэв ийм конвенц байгуулагдвал тэр нь ямар нэг мэдэгдлээс илүү бодитой байх тул Монгол улсын хувьд ч, олон улсын аюулгүй байдал, энх тайванд ч аль алинд нь илүү

үр өгөөжтэй байх юм.

Монгол улсын ашиг сонирхолд нийцэж болох өөр нэг хувилбар нь Ази тивийн цөмийн зэвсэггүй бүс байгуулах тухай хувилбар юм. Газрын зураг дээрээс харвал БНХАУ-ыг тойрсон цөмийн зэвсэггүй бүсүүд бий болж, санаачлагдаж зарим нь шинээр төрөн гарч байна. Энэхүү хандлагыг бүхэлд нь зангидан, цогц болгон залуурдаваас Ази тивийн стратегийн төрхийг өөрчилж ч болох юм. Эцэст нь өгүүлэхэд Монгол улсад мөнхийн анд нөхөр гэж үгүй, бас мөнхийн дайсан гэж үгүй. Монгол улсад харин мөнхийн эрх ашиг, сонирхол гэж байх бөгөөд тэр нь дэлхийн хөгжил, өөрчлөлт, энх тайванд нийцэж байна. Энэхүү ашиг сонирхолын үргэлжлэл нь цөмийн зэвсэггүй статусын тухай Монгол улсын бодлого бөгөөд тэрхүү бодлого нь Монгол улсын үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхолд нийцэхийн хамтаар дэлхий дахины аюулгүй байдал, энхийн төлөө үйлсэд оруулж буй хувь нэмэр болох юм. Бид энэ талаархи асуудлаа олон арга замаар шийдэж болох боловч эцсийн сонголт, шийдвэр маань Монгол улсын үндэсний, аюулгүй байдлын ашиг сонирхолд нийцсэн гэсэн ганц л шалгуур байх юм.

## Олон Улсын Харилцааны Дээд Сургууль

АЛТАН АРСАМЖ

### АЛТАН АРГАМЖ

VOL.3

1/2000

#### REPUBLIC OF TEXAS (1836-1845)

SFS/NUM

Ts. Ganzorig

A giant among US states, vast Texas was once a sovereign nation (1836-1845). Texas was under Spain rule for 300 years. When Mexico became an independent country in 1821, Texas became a Mexican state and new settlers from the United States were welcomed. But soon after, there was a conflict over slavery in the territory of Texas between slave-holding Americans and non-slave Mexico.

The Texans held a convention at Washington on the Brazos and adopted a declaration of independence on March 2, 1836. A constitution modeled after that of the United States was adopted by the new Republic of Texas. The most striking event in the Texas war for independence was the heroic defense of the Alamo in San Antonio. A rebuilt mission, the Alamo was used as a fort by about 180 Americans. After a siege of 12 days by several thousand Mexican soldiers under Santa Anna, the Alamo fell on March 6, 1836, and the garrison was wiped out. Later in the month the Mexicans massacred James Fannin and more than 300 Texas prisoners at Goliad. "Remember the Alamo" and "Remember Goliad" became Texas war cries.

After a successful war of independence against Mexico, the Texans raised the Lone Star flag over their own republic in 1836. This government was officially recognized by the United States and by several European countries including the Netherlands, England and France. The first President was hero of Mexican War General Samuel Houston. Then in 1845 Texas accepted annexation by the United States and was admitted to the Union as the 28th state.

From 1836 to 1845 the public debt grew from 1 million to 8 million dollars. Many believed that the future development of Texas would be greater under the United

States. In 1844 a convention voted for annexation and a state constitution was adopted